

**Дональд Дэвидсон. Ойлголтын схем хэмээх санааны тухайд<sup>131</sup>**

Орчуулсан: Э.Баасандорж, магистр, багш  
МУИС, Философи, шашин судлалын тэнхим

Төрөл бүрийн үнэмшил бүхий философичид ойлголтын схемүүдийн тухайд ярих хандлагатай байдаг. Ойлголтын схемүүд гэдэг бол туршлагыг зохион байгуулах арга хэлбэрүүд юм; эд бол сэрэл мэдрэхүйн өгөгдлийг хэлбэртэй болгодог категорийн тогтолцоо мөн; хувь хүмүүс, соёл эсвэл тодорхой эрин үеийнхний зүгээс болж өнгөрч буй юмсыг харах өнцөг юм гэх мэтээр ярих нь дуулдана. Нэг схемийг нөгөө рүү орчуулах аргагүй байж мэднэ. Тийм бол аливаа хүний онцлог болж буй итгэл үнэмшил, хүсэл эрмэлзэл, найдвар болон мэдлэгийн өөдсүүд өөр ямар нэг схемийг хэрэглэгчийн хувьд үнэн байхгүй. Бодит байдал өөрөө схемээс хамаарч харьцангуй шинжтэй байна: нэг тогтолцоонд жинхэнэ хэмээн тооцож буй зүйл нөгөөд тийм байхгүй.

Цор ганц ойлголтын схем байдаг гэдэгт итгэлтэй байдаг сэтгэгчид хүртэл схем хэмээх ойлголтын нөлөөнд байна; монотейстүүд хүртэл шашинтай байдаг. Бас хэн нэг хүн “бидний ойлголтын схем”-ийг дүрслэхээр зэхсэн гэдгийг шууд утгаар нь хүлээн авбал, ойрын зорилт нь түүнийг өрсөлдөгч тогтолцоонууд байж болно хэмээн үзэхэд хүргэнэ.

Ойлголтын релятивизм нь болчимгүй бөгөөд жигтэй номлол мөн, эсвэл бид үүнийг сайтар ойлгож чаддагсан бол тийм байх байсан. Гол асуудал нь, философид нийтлэг байдагчлан, ухварлагдахуйц (intelligible) байдлаар боловсруулахын зэрэгцээ сэтгэл хөдөлгөм байдлыг хадгалж үлдэх нь хэцүү байдаг явдал юм. Юутай ч би дээр хэлсэнэ үндэслэх гэж үзнэ.

Ойлголтын үлэмж өөрчлөлт нэг бол гүн эсрэгцлийг үүнтэй ижил төрлийн тохирох жишээгээр ойлгоно хэмээн төсөөлөхийг бидэнд уриалах нь бий. Заримдаа, харьцангуйн онолд тодорхойлсон нэгэн зэрэг байдал шиг, аливаа санаа нь, нэмэгдэж ирснээрээ, шинжлэх ухааны бүтэн салбар хүртэл шинэ төрхтэй болохуйц тийм чухал нөлөөтэй байдаг. Аливаа дэг сургуульд үнэн хэмээн тооцдог өгүүлбэрүүдийн жагсаалтад хийсэн өөрчлөлт үнэхээр голлох болж тэрхүү өгүүлбэрүүдэд байсан нэр томъёонуудын утгыг өөрчилсөн мэт санагдаж ч болно. Эрт үед эсвэл алс тэртээ газарт үүсэж хувьссан хэл тодорхой хүрээний үзэгдлүүдийг авч үзэх нөөцөөрөө ихээхэн ялгаатай байж болно. Нэг хэлэнд хялбархан буудаг зүйл нөгөөд буухад хэцүү байж болох бөгөөд энэхүү ялгаа нь хэв маяг болон үнэт зүйлд буй тодорхой ач холбогдол бүхий ижилгүй байдлын цуурай байж болно.

Гэвч иймэрхүү жишээнүүд, зарим тохиолдолд хүчтэй сэтгэгдэл төрүүлэхүйц байдаг ч, тийм ч эрс шинжтэй байдаггүй, харин тэрхүү өөрчлөлт хийгээд эсрэгцлүүдийг нэг хэлний хэрэгслийг ашиглан дүрсэлж бас тайлбарлаж болдог. Хопи болон Англи хэлийг хооронд нь “тохируулахын” (өөрийнх нь үгээр бол) аргагүй тийм харь шинжтэй метафизикийг Хопи хэл нийлүүлж байна гэдгийг үзүүлэх гэхдээ Ворф Хопи хэлнээс түүж орчуулсан өгүүлбэрүүдээ Англи хэл дээр буулгах гэжээ. Кун өнөө буй хувьсгалын дараах хэллэгийг ашиглан хувьсгалын өмнө юмс ямаршуу байсныг хэлэхдээ гарамгай. Куайн бидэнд “ойлголтын схемийнхээ хувьслын хувьшлаас-урьдач (pre-individuative) шатны” тухай ойлгоход тусалдаг. Харин Бергсон уулыг харахдаа аль нэг нутгийн зүгээс харах өнцгийн нөлөөнд үл автах байршлыг хэлж өгдөг.

Ойлголтын релятивизмийн тухайд зонхилон хэрэглэдэг зүйрлэл буюу ялгаатай харах өнцөг хэмээх нь уг зүйлийн сууринд буй парадокст тэрсэлдэг мэт байдаг. Өөр өөр харах өнцөг

<sup>131</sup> 1973 оны 12-р сарын 28-нд Атлантагийн Философийн Холбооны зүүн бүсүүдийн жил тутмын 17-хурлын өмнө ерөнхийлөгчид хандаж хэлсэн үг.

гэдэг нь ойлгогдож болно, гэхдээ өөр өөр харах өнцгүүдийг тоглуулах нийтлэг зохицуулагч тогтолцоо байгаа үед л тийм байх юм; гэтэл нийтлэг тогтолцооны оршихуй нь харилцан үл жишигдэх (incommensurability) байдлын талаарх сэтгэл хөөргөсөн мэдэгдэлтэй харшилддаг. Надад бол, бидэнд ойлголтын эсрэгцэлд хязгаар тавихуйц тийм бодолцож үзэх зүйлсийн тухай ямар нэг санаа хэрэгтэй шиг санагддаг. Парадокс эсвэл зөрчилдөөн гаргахаар эрс шинжтэй үзлүүд байна; ойлгоход асуудалгүй аядуу жишээнүүд ч бий. Зүгээр л жигтэй эсвэл шинэлэг гэдгийг учир утгагүй (absurd) гэдгээс хаагуур нь салгахыг юу шийдэж өгөх вэ?

Хэлтэй байна гэдгийг ойлголтын схемтэй байх гэдэгтэй холбон авч үзэх номлолыг хүлээн авч болох юм. Харилцааг нь ийм гээд үзэж болно: хэрэв ойлголтын схемүүд ялгаатай байдаг бол, хэлнүүд ч бас тийм. Гэхдээ нэг хэлээс нөгөө рүү орчуулга хийж болдог гэдэгт тулгуурлаад өөр өөр хэлээр яригсдын ойлголтын схем ижил төсөөтэй байж болно. Тэгэхээр орчуулгын шалгуурыг судлах явдал бол ойлголтын схемүүдийн адилслын шалгуурын тухайд анхаарч үзэх арга зам мөн. Хэрэв ойлголтын схемүүд хэлтэй холбоотой дээрх шиг замаар холбогддоггүй гэвэл, эх асуудал маань шаардлагагүйгээр давхардаж таарна, яагаад гэвэл, хэрэв тийм байсан бол бид оюун санааг, жирийн категориудтай нь, хэлийг зохион байгуулах бүтэцтэй нь ажиллуулж байгаагаар төсөөлөх ёстой болно. Ийм ярвигтай нөхцөл байдал дор бид хэн эзэн нь болох тухай гарцаагүй асууж таарна.

Нөгөөтээгүүр, *ямар ч* хэл бодит байдлыг сарниулдаг хэмээдэг, оюун санаа юмсыг үнэхээр байгаагаар нь барьж авна гэвэл үгээр дамжуулахгүй байж л тэгэх боломжтой гэх санаа бий. Энэ бол хэлийг, үүнийг хэрэглэж буй хүний үйл эрхлэгч чанараас (agency) тусгаар, хөдөлгөөнгүй (зайлшгүй сарниулагч чанартай хэдий ч) дамжуурга хэмээн ухан ойлгож буй хэрэг мөн; энэ бол хэлний талаарх, тохинуулах аргагүй тийм үзэл гэдэг нь эргэлзээгүй юм. Гэсэн ч, оюун санаа бодит байдалтай ямар ч сарнилтгүйгээр ноцолдож чаддаг бол, оюун санаа өөрөө категори болон ойлголтуудгүй байх ёстой. Ийм хоосон өөрийнсөл (self) бидэнд философийн талбар дахь нэлээд өөр хэсгээс танил болсон. Жишээ нь, эрх чөлөөг тухайн үйл эрхлэгчийн бүх л хүсэл эрмэлзэл, зуршил хийгээд авир үйлээс (dispositions) тусгаар шийдвэрүүдээс бүрддэг зүйл болгон авч үзэх онолууд бий; бас оюун санаа өөрийнхөө хэмээх санааг илэрхийлэх мэдлэгийн тухай онолууд байдаг. Аль ч тохиолдолд, оюун санааг өөрийг нь бүрдүүлж буй зан чанаруудаас (traits) салангид болгожээ; миний хэлсэнчлэн, тодорхой цуваа бүхий сэтгэхүйн хувьд хангалттай танил боловч биднийг үргэлж нөхцөлүүдээс (premises) татгалзахад ятгаж байх учиртай тийм дүгнэлт.

Бид ойлголтын схемийг хэлтэй адилтган үзэж болно, тэгснээр, эсвэл илүү дээрээр, нэгээс олон тооны хэл нэг схем, орчуулах аргагүй хэлнүүдийн олонлог байх боломжийг зөвшөөрнө. Хэлнүүдийг бид оюун сүнснээс (soul) салгаж болдог мэтээр үзэхгүй; хүн бодох чадлыг хадгалж байгаа цагт хэлээр ярих гэдэг нь хүний алдаж болох тийм зан чанар (trait) биш. Иймд өөрийнхөө ойлголтын схемийг түр зуур тайлж орхих замаар ойлголтын схемүүдийг харьцуулах тийм давуу харах өнцгийг олж авах боломж үгүй юм. Тэгвэл хооронд нь орчуулж болоогүй хэлнүүдээр ярьдаг хоёр хүнийг өөр ойлголтын схемтэй хэмээж болох уу?

Харин одоо би гарч ирнэ хэмээн үзэж болох хоёр төрөл бүхий тохиолдлыг авч үзье: орчуулгын бүрэн хийгээд хэсэгчилсэн бүтэлгүйтэл. Нэг хэлээс нөгөө рүү орчуулж болох тодорхой хүрээний өгүүлбэр огт үгүй бол бүрэн бүтэлгүйтэл болно; тодорхой хүрээний өгүүлбэрийг орчуулж болоод өөр тодорхой хүрээний өгүүлбэрийг орчуулах аргагүй бол хэсэгчилсэн бүтэлгүйтэл болно (би боломжит тэгш бус хэмт байдлуудыг үл хэрэгсэнэ). Би бүрэн бүтэлгүйтлийг утга учиртай байх боломжгүй тухайд үндэслэл дэвшүүлээд, хэсэгчилсэн бүтэлгүйтлийн тохиолдлуудыг арай товчхон шинжиж үзэх бодлогоор ажиллана.

Ингээд бүрэн бүтэлгүйтэл хэмээн тооцогддог тохиолдлуудыг авч үзье. Дараах шиг маш энгийн дүгнэлт хийх хүсэл төрж болох юм: ямар нэг үйл ажиллагааг бид өөрсдийнхөө хэл рүү

тайлж ойлгож чадахгүй гэдгийн нотолгоо нь тухайн үйл ажиллагааг хэл яриатай холбогдох зан үйл (behavior) байгаагүй хэмээн үзэх нотолгоо бас мөн. Хэрэв ийн үзэх нь зөв байсан бол, өөрийнхөө хэлэнд хэл хэмээн тайлах аргагүй аливаа хэлбэр бүхий үйл ажиллагаа бол хэл ярианы зан үйл биш хэмээн үзэх ёстой болж магадгүй. Гэхдээ асуудлыг ийн авч үзэх нь хангалтгүй, учир нь энэ нь орчуулагдах бололцоо гэдгийг танил хэл (familiar tongue) буюу хэл байхуйн шалгуур болгохоос гавихгүй. Тогтоол адил, дээрх сэдэв (thesis) өөрийгөө-нотлохдоо тааруу; хэрэв энэ нь үнэн бол, миний бодож байгаачлан, энэ нь үндэслэгээний дүгнэлт болон гарч ирэх учиртай.

Энэ байр суурийн найдварт байдал хэл ба итгэл үнэмшил (belief), хүсэл эрмэлзэл (desire), сэдэмж (intention)<sup>132</sup> гэх мэт хандлагын атрибуцын дунд буй ойр харилцан хамаарлыг тунгааснаар хөгжинө. Нэг талаас хэл ярианд сайтар ялгарсан хэд хэдэн сэдэмж хийгээд итгэл үнэмшил шаардлагатай гэдэг нь тодорхой. Няцашгүй зан алдар нэрийг гялалзуулдаг хэмээн батлан мэтгэж буй хүн, жишээ нь, няцашгүй зан алдар нэрийг гялалзуулдаг гэдэгт итгэж байгаагаа харуулах ёстой, бас үүнд итгэж байгаа гэдгээ харуулахыг санаж зорих учиртай. Нөгөө талаас, бид үүнийг хэлж буй хүний үгсийг өөрсдийнх рүүгээ орчуулж чадахгүй бол ийм нарийн цогц хандлагуудыг мөнөөх хүнд ухварлагдахуйцаар хамаатуулна гэвэл тун боломгүй харагдана. Хэн нэгний хэлийг орчуулах боломжтой байх хийгээд түүний хандлагыг дүрслэх боломжтой байх хоёр тун ойрын харилцан хамааралтай гэдэг нь эргэлзээгүй. Гэсэн ч, энэ харилцан хамаарал нь юу болох талаар илүү ихийг хэлэх боломж бүрдэхээс нааш орчуулагдашгүй хэлнүүдийн эсрэг үүсгэх хэрэг бүрхэг хэвээр үлдэнэ.

Танил хэл рүү, жишээ нь Англи хэл рүү, орчуулах боломжийг орчуулагдах бололцооны харилцан хамаарал транзитив биш гэдэгт тулгуурлаад хэл байхуйн шалгуур байж чадахгүй хэмээн үзэх явдал бий. Энэ бол зарим хэлийг, Санчир хэлийг гэе, Англи хэл рүү бас дахиад Дэлхийн ван хэл ч юм уу, ямар нэг хэл рүү орчуулах боломжтой байхад Дэлхийн ван хэлийг Англи хэл рүү орчуулах боломжгүй гэх санаа юм. Хангалттай олон орчуулагдахуйц ялгаа нийлээд орчуулагдашгүй ялгаа болж болно. Хэл бүрийг өмнөх хэл рүү нь хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлаар орчуулж болох ойр хэлнүүдээс бүрдсэн хэлнүүдийн цувааг төсөөлснөөр, Англи хэл рүү орчуулахад огтоос таардаггүй тийм өөр хэлийг төсөөлж болох юм. Энэхүү алс холын хэлэнд харгалзаад бидэнд бүхэлдээ харь санагдах ойлголтуудын тогтолцоо байх болно.

Ийм төсөөллийн дасгал бидний ярианд ямар нэг шинэ элемент оруулж ирэхгүй хэмээн би бодож байна. Учир нь бид Санчирын хүн Дэлхийн-ван (эсвэл өөр ямар нэг) хэлнээс орчуулж байсан гэдгийг хэрхэн ухаарснаа асууж үзэх учиртай. Санчирын хэлээр яригч нь бидэнд өөрийгөө тийм зүйл хийж байсан хэмээж болно, эсвэл бид түр зууртаа түүнийг бидэнд ийн хэлсэн хэмээн таамаглан үзэж болно. Гэхдээ тэгвэл Санчир хэлний талаарх орчуулга маань зөв байсан эсэх нь гайхмаар зүйл болж таарна.

Кунынхаар бол, өөр өөр шинжлэх ухааны уламжлалд үйл ажиллагаа эрхэлж буй эрдэмтэд (өөр өөр “парадигм” дотор) “өөр өөр ертөнцөд амьдардаг”. Строусоны *Сэрэл Мэдрэхүйн Хязгаарууд* “Ертөнцийг бидний мэддэгээс маш өөр төрөл бүхий ертөнцүүдийг төсөөлөх боломжтой” тухай тайлбараар эхэлдэг.<sup>133</sup> Нэгээс илүү ертөнц байхгүй учраас энэ олон талт байдал (plurality) зүйрлэлийн шинжтэй, эсвэл зүгээр л төсөөллийнх юм. Гэхдээ зүйрлэлүүд нь хоорондоо ижилгүй байна. Строусон боломжит бөгөөд биелсэн-бус ертөнцүүдийг, өгүүлбэрүүд дээр буй үнэний утгыг өөр өөр тогтолцоо бүхий арга замаар дахин хуваарилснаар одоо буй хэлээ ашиглан дүрсэлж болох тийм ертөнцүүдийг төсөөлөхийг санал болгодог. Энэ тохиолдолд гарч

<sup>132</sup> Орчуулагчийн тэмдэглэл: Сэдэл буюу *motive* нь ухамсартай бөгөөд зориудын байх шаардлагагүй. Харин *intention* бол ухамсартай бөгөөд зориудын төлөвийг илэрхийлдэг. Тус үгийг “санаа зорилго” хэмээн орчуулах өөр боломж байсан боловч “сэдэмж” хэмээн холбоо үг ашиглахгүйгээр орчуулахыг илүүд үзэв.

<sup>133</sup> Peter Strawson. *The Bounds of Sense*. London. 1966. p. 15

буй ертөнцүүдийн эсрэгцлийн тодорхой байдал нь ойлголтуудын схем, дүрслэлийн эх сурвалжаа төвшитгөгдсөн (fixed) хэмээн үзэх эсэхээс хамаарна. Нөгөө талаас, Кун бол хоорондоо үл жишигдэх (incommensurable) ойлголтуудын тогтолцоондоо тулгуурлаад нэг ертөнцийг өөр өөрөөр ажигладаг хүмүүсийн талаар бодож үзэх санал тавьдаг. Строусоны авч үзэж буй олон төсөөллийн ертөнц бол нэг л харах өнцгөөс үзэгдэж (эсвэл сонсогдож) —юутай ч дүрслэгдэж— байгаа; Куны нэг ертөнц бол өөр өөр харах өнцгийн үүднээс үзэгдэж байгаа. Энэ нь бидний авч үзэх хоёр дахь зүйрлэл юм.

Эхний зүйрлэлд ойлголт хийгээд агуулгын хэлний дунд зааг гаргахыг шаардана: төвшитгөгдсөн ойлголтын тогтолцоо (төвшитгөгдсөн утга утга бүхий үгсийг) ашигласнаар өөр ертөнцүүдийг дүрсэлж байна. Зарим өгүүлбэрүүд бол дотор нь агуулагдаж буй утга эсвэл ойлголтуудын л улмаас, бусад нь ертөнц ямар байгаагаас шалтгаалж үнэн болно. Боломжит ертөнцүүдийг дүрслэхдээ бид зөвхөн хоёр дахь төрөлд хамаарах өгүүлбэрүүдээр тоглодог.

Харин хоёр дахь зүйрлэл бол нэлээд өөр төрлийн дуализмыг буюу бүрэн схем (эсвэл хэл) хийгээд үл тайлагдсан (uninterpreted) агуулгын дуализмыг дэвшүүлнэ. Хоёр дахь дуализмыг дэвшүүлэх явдал нь эхний дуализмыг дэвшүүлэх явдалтай үл нийцэхийн зэрэгцээ эхний дуализмд хандсан шүүмжээр хүчирхэгжиж байж болно. Яаж тийм байж болохыг тодруулж үзье.

Аналитик-синтетикийн заагийг хэлний талаар ойлгох суурь болгон ашиглахаа болино гэдэг нь хэл хийгээд онолын хооронд цэвэр зааг гаргаж болно гэх санаанаас татгалзах явдал мөн. Утга гэдэг нь, бид сул чөлөөтэйгөөр хэрэглэж болдог шиг, онолоор буюу үнэн хэмээн тооцогдох зүйлсээр бохирдсон байдаг. Фейрабенд энэ тухайд ийн хэлжээ:

Утгын хувирдаггүй чанарын эсрэг бидний дэвшүүлж буй үндэслэл энгийн бөгөөд тодорхой. Энэ нь утгыг тогтоох хуучин онолууд эсвэл харах өнцгүүдийн утгын тогтооход оролцдог зарчмуудын зарим нь шинэ . . . онолуудынхтай нийцгүй байх тохиолдол олон гардаг гэдгээс урган гарч байгаа юм. Энэ нь асуудал үүсгэж буй . . . хуучин зарчмуудыг үгүй хийгээд, тэдгээрийг шинэ . . . онолын зарчим, теоремуудаар орлуулснаар үүсээд буй зөрчлийг шийдвэрлэх нь хэвийн үзэгдэл гэдгийг онцолдог. Тэгээд, ийм явц хуучин утгуудыг үгүй хийх явдал өөд хөтөлнө гэдгийг харуулснаар дүгнэлтээ хийдэг.<sup>134</sup>

Ингээд бид тусдаа байх ойлголтын схемүүдийг бий болгох томъёотой болсон шиг харагдана. Аливаа хэлээр яригсад өмнө худал хэмээн үздэг байсан чухал хүрээ бүхий өгүүлбэрүүдийг үнэн хэмээн зөвшөөрөх болсноор (бас эсрэгээрээ ч байж болох нь мэдээж) хуучин схемээс шинийг гарган авч байна. Энэ өөрчлөлтийг бид зүгээр л хуучин худал байсан зүйлсийг үнэн болгож харж буй хэрэг мэтээр дүрслэх ёсгүй. Учир нь аливаа үнэн бол хэллэг (proposition) бөгөөд мөнөөх улсын аливаа өгүүлбэрийг үнэн хэмээн хүлээн зөвшөөрөхдөө үнэн хэмээн хүлээн зөвшөөрөхөд хүрч буй зүйл нь мөнөөх өгүүлбэрийг өмнө нь худал хэмээн тооцож байхдаа хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж байсан тэр зүйлтэй ижил биш. Тэр өгүүлбэр одоо шинэ хэлэнд хамаарч байгаа учраас энэ өөрчлөлт мөнөөх өгүүлбэрийн утга дээр гарсан байна.

Шинэ (магадгүй илүү дээр) схемүүд хэрхэн шинэ бөгөөд илүү дээр шинжлэх ухааны үр дүнд гарч ирж буй талаарх энэ зураглал Патнам, Фейрабенд зэрэг шинжлэх ухааны философичид хийгээд Кун зэрэг шинжлэх ухааны түүхчдийн гаргаж өгсөн зураглалтай тохирно. Өөр зарим философичдын дэвшүүлж буй зүйлээс бид хөгжингүй шинжлэх ухаанд хэлээ уялдуулж хөглөвөл ойлголтын схемээ хөгжүүлнэ гэх дээрхтэй холбоотой санаа урган гарна. Ингээд Куайн, Смарт нар хоёул, гэхдээ бас бага зэрэг ялгаатайгаар, өнөө бидэнд буй ярих арга хэлбэрүүдийг зан үйлийн талаарх нухацтай шинжлэх ухааныг боломжгүй болгож байна хэмээн халаглан улайсан бий. (Виттгенштейн, Райл нар дээрхтэй төстэй зүйлсийг халаглалгүйгээр хэлсэн.) Эдгэрэл

<sup>134</sup> Paul Feyerabend, "Explanation, Reduction, and Empiricism," in *Scientific Explanation. Space, and Time: Minnesota Studies in the Philosophy of Science*, Vol. III, Minneapolis. 1962, p. 82.

гэдгийг, Куайн, Смарт нар үзэхдээ, хэрхэн ярьж байгаагаа өөрчлөх явдал хэмээжээ. Смарт биднийг шинжлэх ухааны хувьд дардан байх материализмын зам дээр тавихын тулд уг өөрчлөлтийг дэвшүүлдэг (бас урьдчилан тооцоолдог); Куайн бол цэвэр багтаамжийн хэлний (extensional language) замыг гаргаж өгөхөд илүүтэй анхаарсан. (Магадгүй, өнөө бидэнд буй схем хийгээд хэлийг багтаамжийн бас материалист хэл хэмээн ойлговол хамгийн дээр гэдгийг нэмж хэлэх учиртай байх.)

Хэрэв бид дээрх зөвлөмжийг дагана гэвэл, би өөрөө шинжлэх ухаан эсвэл ойлгохуйг ахиц гаргадаг хэмээн бодохгүй ч, ёс суртахууны ахиц гарч болох юм хэмээн бодно. Гэвч одоо бол, тийм өөрчлөлт гарсан гэвэл, үүнийг суурь ойлгоцын аппаратад засвар оруулж байна гэж хэлэх нь зөв эсэх тухай асуудлыг л авч үзэж байгаа. Тэднийг ийн хэлэхэд тулгарах хүндрэлийг өндөрт өргөхөд амархан. Би Шинжлэх Ухааны Хэлний Сайдын алба хашдаг байгаад, шинэ хүнийг, жишээ нь сэтгэл хөдлөл, сэтгэл мэдрэмж, бодол, сэдэмж заасан үгсийг хэрэглэхийг болиулж, оронд нь оюуны янз бүрийн юмстай их бага хэмжээгээр адил хэмээн тооцогдох физиологийн төлөв хийгээд үйл явдлуудын тухай ярьдаг болгохыг хүссэн гээд төсөөлье. Мөнөөх хүн шинэ хэлээр яривал, зөвлөгөөг маань хайхарсан эсэхийг яаж мэдэж хэлэх вэ? Миний л мэдэж байгаагаар, гялалзсан шинэ хэлцүүд, физиологийн идэвхжилийг заадаг байсан хуучин хэлнээс авсан хэдий ч, мөнөөх хүний аманд хуучны эргэлзээтэй оюуны ойлголтуудын дүрд тоглож байж болно.

Миний л мэдэж байгаагаар түлхүүр хэлц нь ийм юм. Хуучин үгсийн сангаас заримыг нь эсвэл бүгдийг нь үлдээсэн гэдэг нь өөрөө бол шинэ схемийг өмнөхтэй ижил, эсвэл хуучнаас ялгаатай хэмээн шүүн дүгнэх суурь болохгүй гэдэг нь л тодорхой байна. Тэгэхээр, эхэндээ сэтгэл догдлом нээлт мэт сонсогдож байсан зүйл нь — үнэн гэдэг нь ойлголтын схемүүдэд харьцангуй байна гэх — өгүүлбэрийн үнэн нь харьяалагдаж буй хэлэндээ (өөр бусад зүйлс бас байгаа) харьцангуйгаар үнэн байна гэх танил бөгөөд онц биш баримтаас хэтрэхгүй гэдгийг үүнээс харж байна. Куны шинжлэх ухаанчид, өөр өөр ертөнцөд амьдрахын оронд, Вебстерийн толь хэрэгтэй хүмүүсийн адилаар, хэдэн үгний наана цаана л байж болох юм.

Аналитик-синтетикийн заагийг орхих нь ойлголтын релятивизмийг тайлбарлахад тустай гэдэг нь батлагдаагүй. Гэхдээ аналитик-синтетикийн заагийг ойлголтын релятивизмийг түшихэд хэрэглэж болох зүйлийн үүднээс, тодруулбал эмпирик агуулгын талаарх санааны үүднээс тайлбарладаг. Аналитик хийгээд синтетикийн дуализм бол илтгэж буй утга бас эмпирик агуулгынхаа улмаас үнэн (эсвэл худал) болдог хэсэг өгүүлбэр хийгээд ямар ч эмпирик агуулгагүйгээр, дан утгынхаа хувьд үнэн (эсвэл худал) болдог өөр хэсэг өгүүлбэрүүдийн дундах дуализм юм. Хэрэв энэ дуализмыг орхивол, утгын талаарх үүнтэй хамт явж буй ойлгоцыг орхих боловч эмпирик агуулгын талаарх санааг гээх албагүй: хэрэв бид хүсвэл бүүх өгүүлбэрийг эмпирик агуулгатай хэмээн үзэж болно. Эмпирик агуулгыг эргээд баримтыг, ертөнцийг, туршлагыг, сэрэл мэдрэхүйг, сэрэл мэдрэхүйн цочроолыг эсвэл төстэй ямар нэг зүйлийг заагч чанараар тайлбарлах болсон. Утга бидэнд категори буюу хэлний зохион байгуулагч бүтэц гэх мэт зүйлсийн тухайд ярих арга замыг өгдөг; гэхдээ өмнө үзсэнчлэн, утга хийгээд аналитик чанарыг орхихын хажуугаар хэлийг ойлголтын схемийг биежүүлэгч болгон үзэх санааг хадгалж үлдэх боломжтой. Иймд аналитик-синтетикийн дуализмын оронд ойлголтын схем хийгээд эмпирик агуулгын дуализмтай болно. Энэ шинэ дуализм бол оршин тогтнох аргагүй болсон аналитик-синтетик заагаас тасарч үлдсэн эмпирицизмийн, бас эмпирик агуулгыг өгүүлбэр өгүүлбэрээр тухайлан хуваарилж болно гэх ажиллах аргагүй санаанаас тасарч үлдсэн редукционизмын суурь юм.

Схем, агуулгын буюу зохион байгуулагч систем хийгээд зохион байгуулалтад орохоор хүлээж байдаг ямар нэг юмсын талаарх энэ хоёр дахь дуализмыг би ухварлагдахуйц бөгөөд өмгөөлөгдөхуйц байх аргагүй хэмээн сонордуулмаар байна. Энэ бол өөрөө эмпирицизмийн

догма бөгөөд, гуравдугаар догма мөн. Хэрэв бид үүнийг орхивол эмпирицизм хэмээн дуудаж болох ямар нэг тусгаар зүйл үлдэх эсэх нь тодорхой биш учраас энэ нь гуравдугаар, магадгүй эцсийн догма болж байгаа юм.

Схем-агуулгын дуализмыг олон янзаар томъёолж иржээ. Энд зарим жишээг дурдъя. Эхнийх нь Ворфийнх бөгөөд Сапирийн дэвсгэр дээр үүнийгээ боловсруулжээ. Ворф ийн хэлсэн байна: ... хэл туршлагын зохион байгуулалтыг бий болгодог. Бид хэлийг илэрхийллийн техник мэт үзэж, хэл юун түүрүүнд сэрэл мэдрэхүйн туршлагын урсгалыг ангилж, цэгцэлснээр тодорхой ертөнцийн-эрэмбийг бий болгодог . . . Өөрөөр хэлбэл, хэл нь шинжлэх ухааны хийдэгтэй ижил зүйлийг арай түүхий гэхдээ бас илүү өргөн бөгөөд олон талт байдлаар хийдэг . . . Иймд бид, хэл-зүйн суурь дэвсгэр нь ижил, эсвэл түүнийг нь ямар нэг аргаар жишиж хэмжих боломжтой биш л бол ажиглагч бүр ертөнцийн нэг ижил зураглалын талаарх нэг ижил физик нотолгоогоор удирдуулдаг хэмээн үзэх, харьцангуй тухай шинэ зарчимтай танилцаж байна.<sup>135</sup>

Бидэнд шаардлагатай бүрдлүүд бүгдээрээ энд байна: зохион байгуулагч хүчин болох хэл нь шинжлэх ухаанаас илэрхий заагтай биш; зохион байгуулалтад ордог зүйлийг өөрөөр бас “туршлага,” “сэрэл мэдрэхүйн туршлагын урсгал” бас “физик нотолгоо” гэдэг; бас эцэст нь, өөр хооронд нь орчуулах (“жишиж хэмжих”) аргагүй байдал. Өөр хооронд нь орчуулах аргагүй байдал бол ойлголтын схемүүдийн ялгааны зайлшгүй нөхцөл мөн; туршлага эсвэл нотолгоотой үүсгэх нийтлэг харьцаа нь орчуулга бүтэлгүйтсэн нь хэл эсвэл схемүүдтэй холбоотой гэх баталсан өгүүлбэрийг утгат чанартай болгоход туслах учиртай байв. Бүх схемээс гадна ямар нэг нийтлэг бөгөөд нейтрал зүйл бий гэдэг нь уг санааны салшгүй нэг хэсэг мөн. Нийтлэг гэх тэрхүү зүйл нь, мэдээж хэрэг, хэлнүүдийн эсрэгцэж буй тэр асуудал байж болохгүй, үгүй бол орчуулга хийх боломж бүрдэх байсан. Иймд Кун саяхан ийн бичжээ:

Философичид өнөө бол цэвэр сэрэл мэдрэхүйн-өгөгдөл бүхий хэл олно гэх найдвараа гээсэн . . . гэхдээ шаардлагатай хэмжээнд онолоос ангид байх, байгальтай төвөггүй байдлаар уягдсан үгсээс л бүрдэх суурь үгсийн сангийн нөөцөд тулгуурлаад онолуудыг хооронд нь харьцуулж болно хэмээн үзэх хүн олон хэвээр байна. Фейрабенд бид хоёр тийм үгсийн сан байх боломжгүй тухайд тодорхой хэмжээгээр үндэслэл дэвшүүлсэн. Нэг онолоос нөгөө рүү хийх шилжилт дунд үгсийн утга эсвэл хэрэглэгдэх нөхцөл нь үл ялиг өөрчлөгдсөн байдаг. Хүч, масс, элемент, нэгдэл, эс гэх мэт хувьсгалын өмнө хэрэглэж байсан гэмдгүүдийн дийлэнх нь хувьсгалын дараа ч хэвээр үлддэг боловч —эдгээрийн зарим нь байгальтай хэрхэн уягдаж байгаа нь ямар нэг талаар өөрчлөгдсөн байдаг. Тэгэхээр нэг нэгнээ залгамжилсан онолуудыг бид үл жишигдэх (incommensurable) гэдэг.<sup>136</sup>

"Үл жишигдэх" гэдэг бол, мэдээж хэрэг, Кун, Фейрабенд нарын “үл орчуулагдах” гэдгийг илэрхийлдэг тийм үг мөн. Зохион байгуулалтад орохоор хүлээж буй нейтрал агуулгыг байгаль нийлүүлж өгдөг.

Фейрабенд өөрөө “тогтолцоо эсвэл хэлнээс гадна байх харах өнцгийг сонгох замаар” эсрэгцэж буй схемүүдийг харьцуулж болох юм гэсэн санааг илэрхийлсэн бий. Бүх схемээс тусгаар “хүний туршлага үнэхээр оршиж байгаа үйл явц болохынхоо хувьд одоо ч байгаа”<sup>137</sup> учраас тэгэх боломжтой хэмээн тэр найджээ.

Ижилхэн, эсвэл төстэй гэж болох бодлуудыг Куайн олон газар илэрхийлсэн байна: “Бидний мэдлэг эсвэл итгэл үнэмшил хэмээдэг зүйлсийн бүхэллэг байдал . . . бол хүний бүтээсэн таар

<sup>135</sup> Benjamin Lee Whorf, *Language, Thought and Reality: Selected Writings of Benjamin Lee Whorf*, ed. J.B. Carroll, New York, 1956, p. 55.

<sup>136</sup> Thomas Kuhn, "Reflection on my Critics" in *Criticism and the Growth of Knowledge*. eds. I. Lakatos and A. Musgrave, Cambridge, 1970, pp. 266, 267.

<sup>137</sup> Paul Feyerabend, "Problems of Empiricism," in *Beyond the Edge of Certainty*. ed. R.G. Colodny, Englewood Cliffs, New Jersey, 1965, p. 214.

бөгөөд зах хавиараа л туршлагад нөлөөлдөг . . .”;<sup>138</sup> “. . . бүрэн шинжлэх ухаан гэдэг бол хязгаарын нөхцөлүүд нь туршлага болдог хүчний талбар лугаа юм”;<sup>139</sup> “Эмпирицистийн хувиар би . . . шинжлэх ухааны ойлголтын схемийг . . . өнгөрсөн туршлагаас мэдэж авсан зүйлсээрээ ирээдүйн туршлагыг урьдчилан тооцоолох хэрэгсэл хэмээн үздэг.”<sup>140</sup> Бас дахиад:

Бид ямар нэг аргаар бодит байдлыг таньж бас ялгаж болох олон объект болгон задалсаар байдаг . . . Биднийг объектуудын талаар ярьдаг гэж хэлбэл бид юм хэлж байна ч гэж тоохооргүй тийм ужиг байдлаар бид объектуудын тухай ярьдаг; учир нь бид өөр юуны талаар ярих билээ? Объектчилох хэв загвар маань хүний угт үл хувирах шинжтэйгээр байх зан чанар мөн учраас биш, харин бид харь өгүүлбэрүүдийг орчуулах эсвэл ойлгох чухам тэр явцдаа ямар ч харь хэв загварыг өөрсдийнхдөө нутагшуулахаас аргагүй байдаг учраас өөрөөр яаж ярьж болох тухай юм хэлэхэд хэцүү байдаг.<sup>141</sup>

Ялгааг тодорхойлох тестийг мөн л орчуулах аргагүй байдал эсвэл орчуулгын хүндрэл гэжээ: “. . . буйд байх тэр дамжуургыг өөрсдийнхөөсөө эрс ялгаатай хэмээх явдал бол орчуулах явц нь дардан байдаггүй гэж хэлснээс өөрцгүй.”<sup>142</sup> Гэхдээ харь нэгэнд “хувьшлаас хэтийдсэн, төсөөлж байгаагүй хэв загвар”<sup>143</sup> байж таарахаар тийм их бэржгэр бартаа байж болно.

Гол санаа нь тэгэхээр, аливаа нэг зүйлийг бид орчуулж чадах эсэхээс үл хамаараад, мөнөөх зүйл нь туршлагатай (байгаль, бодит байдал, сэрэл мэдрэхүйн өдөөлт) тодорхой харилцаанд (урьдчилан тооцоолох, зохион байгуулах, тулгарах эсвэл таарах) оршиж байвал, тэр зүйл хэл болох бөгөөд ойлголтын схемтэй холбоотой гэдэг тухайд аж.

Дүр зураг хийгээд зүйрлэлүүд үндсэн хоёр бүлэгт хуваагдана: ойлголтын схемүүд (хэл) ямар нэг зүйлийг *зохион байгуулдаг*, аль эсвэл түүнийг тааруулдаг (“шинжлэх ухааны өвөө . . . сэрэл мэдрэхүйн өдөөлтүүддээ тааруулахаар мушгидаг”<sup>144</sup> гэдэг шиг). Эхний бүлэгт (туршлагын урсгалыг) *тогтолцоонд оруулах, зааглах* явдал бас хамаарна; хоёр дахь бүлэгт оруулж болох өөр жишээнүүд гэвэл (туршлагын онц шүүхийг /the tribunal of experience/) урьдчилан тооцоолох, тайлбарлах, түүнтэй тулгарах зэрэг юм. Зохион байгуулалтад орж буй, эсвэл схемтэй таарах ёстой тэр нэгж юмстай холбоотойгоор мөн адил гол хоёр сагааг илрүүлж болно хэмээн бодож байна: энэ нь бодит байдал (орчлон, ертөнц, байгаль) байна эсвэл туршлага (өнгөрөн одох үзэгдлүүд, өнгөн цочрол, сэрэл мэдрэхүйн өдөөлт, сэрэл мэдрэхүйн өгөгдөл буюу өгөгдмөл зүйл) байна.

Дангаараа байгаа аливаа объектыг өөр объектууд агуулж байгаа эсвэл объектыг бүрдүүлж байгаа хэмээн ойлгоогүй л бол, тухайн объектыг (цэцэг, байгаль гэх мэт) зохион байгуулалтад оруулах тухай ухагдахуунд тодорхой утга хавсаргах боломжгүй. Хувцасны шүүгээг зохион байгуулалтад оруулахаар зэхсэн хүн дотор нь буй юмсын байршлыг хуваарилдаг. Хэрэв гутал, цамц хоёрыг биш шүүгээг зохион байгуулалтад оруул гэсэн бол мэгдмээр хэрэг болно. Номхон далайг яаж зохион байгуулах вэ? Эргүүдийг нь тэгшилж, магадгүй арлуудынх нь байршлыг өөрчилж, загаснуудыг нь устгаснаар тэгж болох юм.

Аливаа хэл өөр нэг хэлэнд буй ямар ч энгийн предикаттай багтаамжаараа таарахгүй байх тийм энгийн предикатуудыг агуулж байж, эсвэл бүр тухайн хэлний ямар ч предикатыг

<sup>138</sup> W.V.O. Quine, "Two Dogmas of Empiricism," reprinted in *From a Logical Point of View*. 2nd edition, Cambridge, Mass., 1961, p. 42.

<sup>139</sup> Мөн тэнд

<sup>140</sup> Мөн тэнд.. p. 44

<sup>141</sup> W.V.O. Quine, "Speaking of Objects," reprinted in *Ontological Relativity and Other essays*. New York. 1969. p. 1.

<sup>142</sup> Мөн тэнд. p. 25

<sup>143</sup> Мөн тэнд. p. 24

<sup>144</sup> "Two Dogmas of Empiricism," p. 46.

агуулахгүй байж болно. Тодорхой тохиолдлуудад энэ санааг гаргах боломжийг бий болгож буй зүйл бол хоёр хэлэнд нийтлэг байгаа, ижил объектуудыг хувьшуулж буй ойлголтууд бүхий онтологи юм. Орчуулгын тасалдал хангалттай ойр болсон үед эдгээрийн талаар тодорхой авч үзэж болно, учир нь ерөнхийдөө амжилттай болсон орчуулгын дор буй суурь нь бүтэлгүйтлийг ухварлагдахуйц болгоход хэрэгтэй зүйлсийг гаргаж өгдөг. Гэхдээ бид илүү том тоглоомоор хөөцөлдөж байсан билээ: бид огтхон ч орчуулах аргагүй хэл байна гэдгийг ойлгомжтой болгох гэсэн. Эсвэл, санаагаа өөр өнцгөөс тавивал, бид, танил хэлц рүү орчуулагдах бололцооноос хамаардаггүй, эсвэл тийм бололцоог гаргаж ирдэггүй тийм хэл байхуйн шалгуурыг эрж байсан. Би байгалийн шүүгээг зохион байгуулалтад оруулах дүр зураг тийм шалгуурыг гаргаж өгөхгүй гэж үзэж байгаа юм.

Нөгөө төрөлд хамаарах объект буюу туршлага тэгвэл яах вэ? *Үүнийг* зохион байгуулж буй хэлний талаар авч үзэж болох уу? Өмнөхтэй тун төстэй хүндрэлүүд гарч ирнэ. Зохион байгуулалт хэмээх ухагдахуун зөвхөн олонлог чанарт л хамаарна. Гэхдээ бид туршлагыг ямар ч олонлог чанараас бүрддэг хэмээн үзсэн бай — товч оо алдах, хөлийн хуруугаа цохих, дулааныг мэдрэх эсвэл жимбүүр хөгжим сонсох гэх мэт үйл явдлууд — танил зарчмуудынхаа дагуу хувьшуулах (individuate) ёстой болно. *Тийм* нэгж юмсыг зохион байгуулдаг хэл бидэнд байгаа шиг тийм л хэл байх учиртай.

Туршлага (бас өнгөн цочрол, сэрэл мэдрэмж, сэрэл мэдрэхүйн өгөгдөл гэх мэт нэг ангийнхан нь) нь санааг зохион байгуулна гэвэл өөр нэг, бүр ч илэрхий хүндрэл гарч ирнэ. Учир нь *зөвхөн* туршлага, сэрэл мэдрэмж, өнгөн цочрол эсвэл сэрэл мэдрэхүйн өгөгдлийг л зохион байгуулдаг зүйлсийг хэрхэн хэл гэж тооцож болох билээ? Хутга ба сэрээ, зам хийгээд уулс, байцаа бас хаант улсуудыг ч бас зохион байгуулалтад оруулах хэрэгтэй шүү дээ.

Энэ сүүлийн цохож тэмдэглэсэн зүйлийг ойлголтын схем бол сэрэл мэдрэмжтэй учраа таарах (cope with) арга зам гэх баталмалд хариу болж таарахгүй мэт сонсогдож мэдэх нь эргэлзээгүй; бас би тийм гэдэгтэй санал нийлж байна. Гэхдээ туршлагыг *зохион байгуулах* талаарх санааг л энд авч үзэж байснаас, туршлагатай *учраа таарах* (эсвэл таарах, нэг бол үүнтэй тулгарах) тухай санааг авч үзээгүй. Би эхэнд буй ойлголтод нь хариу өгснөөс биш удаахад нь биш. Одоо харин хоёр дахь санааг ашиглаад илүү дээр зүйлд хүрч болох эсэхийг үзье.

Зохион байгуулалтын тухай ярианаас таарамжийн тухай яриа руу шилжих юм бол анхаарлаа хэлний заагч (referential) аппаратаас — предикат, квантор, хувьсагч хийгээд ганц тоо бүхий нэр томъёонууд — бүхэл өгүүлбэрүүд рүү шилжүүлнэ. Өгүүлбэрүүд л урьдчилан тооцоолдог (эсвэл урьдчилан тооцоололд хэрэглэгддэг), өгүүлбэрүүд л юмстай учраа таарч эсвэл учраа ололцдог, сэрэл мэдрэхүйн өдөөгчидтэй маань таардаг, нотолгоотой харьцуулагдаж эсвэл эсрэгцдэг. Туршлагын онц шүүхтэй тулгардаг зүйл нь ч бас өгүүлбэр боловч үүнтэй тулгарахдаа өгүүлбэрүүд хамтаараа байх ёстой нь мэдээж хэрэг билээ.

Туршлага, сэрэл мэдрэхүйн өгөгдөл, өнгөн цочрол эсвэл сэрэл мэдрэхүйн өдөөлтүүдийг хэлний цор ганц агуулга гэж хэлэх гээгүй. Элм гудамжны тоосгон байшингуудын талаарх яриаг эцсийн дүндээ сэрэл мэдрэхүйн өгөгдөл эсвэл хүртэхүй болгон үгчлэн задлах боломжтой хэмээдэг онол байдаг нь үнэн боловч тийм редуccionист үзэл бол бидний авч үзэж буй ерөнхий байр суурийн экстрим бөгөөд үнэмшил муутай хэлбэр л юм. Өгүүлбэрийг (өгүүлбэр гэдэг нь бүтэн онолыг ч багтааж байж болно) хүлээн зөвшөөрөх бүх *нотолгоог* сэрэл мэдрэхүйн туршлага гарган өгдөг гэх ерөнхий байр суурь. Онол эсвэл өгүүлбэрийг нотолгооноос төрөн гардаг гэдгээс үзвэл эдгээр нь сэрэл мэдрэхүйн өдөөлтүүдтэй маань таардаг, туршлагын онц шүүхтэй амжилттай тулгардаг, ирээдүйн туршлагуудыг урьдчилан тооцоолдог нэг бол өнгөн цочролуудын хэв загвартай учраа таардаг.

Үйлийн нийтлэг курст, боломжит нотолгооноос онол төрж болох ч гэлээ худал байж бас болно. Гэхдээ энд үнэхээр хандах боломж бүхий нотолгоог л зөвхөн авч үзээгүй; өнгөрсөн, одоо,



ирээдүй дэх боломжит сэрэл мэдрэхүйн нотолгоонуудын бүрэн байдлыг авч үзэж байгаа. Энэ юу гэсэн үг байж болох талаар эргэцүүлэхийн тулд завсарлага авах хэрэггүй. Гол санаа нь, аливаа онол боломжит сэрэл мэдрэхүйн нотолгоонуудтай таарч эсвэл өөдөө харна гэдэг нь тэр онол үнэн гэсэн үг болох тухайд юм. Хэрэв аливаа онол физик объектууд, тоо эсвэл олонлогуудыг квантчилж байвал, энэ нэгж юмсын талаар өгүүлж буй зүйл нь мөнөөх онол бүхэллэг байдлаараа сэрэл мэдрэхүйн нотолгоотой таарч байгаа гэдэгт тулгуурлаад үнэн болно. Одоо энэ харах өнцгөөс, аливаа хүн тийм нэгж юмсыг баримтын үндэс (posit) хэмээн нэрлэж болно. Аливаа зүйл нь баримтын үндэс болдоггүй зүйлтэй эсрэгцэж байвал, бидэнд тухайн зүйлийг баримтын үндэс хэмээн үзэх учир бий. Харин тэр баримтын үндэс болдоггүй зүйл нь сэрэл мэдрэхүйн туршлага юм —ядаж л гол санаа нь энэ.

Баримттай таарах, баримтын үүднээс үнэн байх гэх зэрэгтэй адилаар, туршлагын бүрэн байдалтай таарах гэдэг ухагдахуунд буй төвөгтэй зүйл гэвэл үнэн байх хэмээн энгийн ойлголт дээр ямар нэг ухварлагдахуунц зүйл ер нэмдэггүй явдал нь мөн. Нотолгоо эсвэл баримтын оронд сэрэл мэдрэхүйн туршлагыг ярих нь нотолгооны уг чанар эсвэл эх сурвалжийн талаарх тодорхой үзлийг илэрхийлдэг ч ойлголтын схемийг тулгаж шалгах аливаа нэгж юмыг ертөнц дээр нэмдэггүй. Сэрэл мэдрэхүйн нотолгооны бүрэн байдлыг байгаа бүх нотолгоо хэмээн үзвэл, бидэнд хэрэгтэй зүйл энэл гэсэн үш юм; бас байгаа бүх нотолгоо гэдэг нь бидний өгүүлбэр эсвэл онолыг үнэн болгоход шаардлагатай зүйл мөн. Юу ч, гэхдээ, *ямар ч зүйл* өгүүлбэр эсвэл онолыг үнэн болгодоггүй: туршлага, өнгөн цочрол, ертөнц өгүүлбэрийг үнэн болгож үл дөнгөнө. Туршлага тодорхой курстэй *гэдэг*, арьс маань дулаацаж эсвэл цоордог гэдэг, ертөнц хязгааргүй гэдэг баримтуудыг бид өгүүлбэр эсвэл онолыг үнэн болгодог хэмээн яримаар байгаа бол, эд тэгдэг. Гэхдээ энэ санааг баримтын тухай дурдалгүйгээр хэлбэл илүү дээр. “Миний арьс дулаахан байна” гэх өгүүлбэр миний арьс дулаахан байгаа үед зайлшгүй бөгөөд хүрэлцээтэйгээр үнэн байна. Энд баримт, дэлхий, туршлага эсвэл нотолгооны хэлтэрхийг заасан юу ч алга.<sup>145</sup>

Хэл эсвэл ойлголтын схемүүдээ ямар нэг нэгж юмтай таардаг хэмээх ухагдахууны үүднээс тодорхойлж харуулах гэсэн оролдлого тэгэхээр ямар нэг зүйл хэрэв үнэн байх юм бол хүлээн зөвшөөрөгдөхүйц ойлголтын схем эсвэл онол болно гэх энгийн бодол руу бууж очлоо. Нэг схемийг хуваалцаж буй хүмүүс нарийн хэсгүүдийн тухайд зөрж байх боломжийг үлдээхийн тулд *дийлэнх талаараа* үнэн гэж хэлсэн нь дээр байж ч болно. Тэгэхээр биднийхээс өөр ойлголтын схемийн шалгуур одоо ийм болж байна: олон талаар үнэн боловч орчуулах аргагүй. Энэ бидэнд ачтай шалгуур мөн эсэх тухай асуудал бол бид орчуулгын талаарх ухагдахуунаас тусгаар байдлаар үнэний тухай ухагдахууныг хэлэнд хэрэглэгдэж буйнх нь хувьд хэр сайн ойлгож байгаа талаарх асуулт л юм. Хариулт нь, миний үзэж байгаагаар, бид үүнийг тусгаар байдлаар огтоос ойлгодоггүй.

Бид “Цас бол цагаан” гэдэг нь цас цагаан үед л зайлшгүй бөгөөд хүрэлцээтэй үнэн болно” (“‘Snow is white’ is true if and only if snow is white”) гэх мэт өгүүлбэрүүдийг тривиал үнэн гэж ойлгодог. Гэхдээ ийм Англи өгүүлбэрүүд бүрэн байдлаараа Англи хэлэнд үнэн гэх ойлголтын багтаамжийг хосгүй байдлаар тогтоодог. Тарски энэ ажиглалтаа ерөнхийлөөд үнэний талаарх онолуудын тест болгосон: Тарскигийн Т зөвшилцөл ёсоор, L хэлэнд шаардлага хангасан үнэний онол нь L-ийн бүх өгүүлбэрт, L нь Англи хэл байх үед “s”-ийг s-ийн дүрслэлээр орлуулж, “p”-г s-ээр өөрөөр нь орлуулахад, харин L нь англи хэл биш үед s-ийг Англи хэл рүү орчуулснаар “p байвал s нь зайлшгүй бөгөөд хүрэлцээтэйгээр үнэн болно” гэх хэлбэр бүхий томъёоллыг гаргаж байх ёстой.<sup>146</sup> Энэ бол үнэний тодорхойлолт биш гэдэг нь, бас хэлнүүдэд ерөнхийд нь үйлчлэх

<sup>145</sup> Энд онцолсон зүйлсийг би "True to the Facts," *The Journal of Philosophy*. Vol. 66 (1969). pp. 748-764-д хамгаалсан.

<sup>146</sup> Alfred Tarski, "The Concept of Truth in Formalized Languages," in *Logic, Semantics, Metamathematics*. Oxford, 1956.

цор ганц тодорхойлолт эсвэл онол байна гэх санааг далдуур хэлж байгаа ч хэрэг биш гэдэг нь мэдээж юм. Юутай ч, Т зөвшилцөл үнэний талаарх бүх тусгайлсан (specialized) ойлголтод нийтлэг байх чухал шинжийг батлан мэдэгдэж чадахгүй ч санал болгож байгаа юм. Ингэхдээ бидний мэдэж буй хэл рүү орчуулга хийх ухагдахууны салшгүй хэрэглээг гаргаснаар амжилт олдог. Үнэний тухай ойлголтыг хэрхэн хэрэглэдэг талаар бидэнд буй хамгийн сайн интуицыг Т зөвшилцөл биежүүлж байгаа учраас, хэрэв тест нь үнэний талаарх ухагдахууныг орчуулгын талаарх ухагдахуунаас салгаж болно гэх үзлээс хамаарч байгаа бол тэр тестэд аливаа ойлголтын схемийг биднийхээс эрс ялгаатай гэх тийм ч их найдвар үгүй шиг харагдаж байна.

Тэгвэл утгуудын төвшитгөсөн нөөц (fixed stock of meanings) ч, онолоос-нейтрал бодит байдал ч ойлголтын схемүүдийг харьцуулах суурь гарган өгч чадахгүй. Хэрэв ийм суурийг хооронд нь жишишгүй схемүүдийн дунд нийтлэг байдаг зүйл хэмээн ухан ойлгож байгаа бол цаашид тийм суурийг эрэх нь алдаа болно. Энэ эрлийг орхихдоо бид дотор нь схем бүр байр суурьтай байж, харах өнцөг гарган өгдөг дан орон зайн талаарх зүйрлэлийг утгат чанартай болгох гэж оролдохоо болино.

Одоо арай даруухан арга барилыг авч үзье: орчуулгын бүрэн биш, хэсэгчилсэн бүтэлгүйтэл. Энэ нь ойлголтын схемүүдэд буй нийтлэг хэсгүүдэд хандсанаар эдгээрийг өөрчилж бас дунд нь буй эсрэгцлүүдийг ухварлагдахуйц болгох боломжийг танилцуулдаг. Дундын утга, ойлголт, итгэл үнэмшлийн тухайд авч үздэггүй тайлал эсвэл орчуулгын талаарх онол л бидэнд хэрэгтэй.

Итгэл үнэмшил хийгээд утгын харилцан хараат байдал хэл ярианы зан үйлийн (speech behavior) талаарх тайллын хоёр талд буй харилцан хараат байдлаас урган гардаг: итгэл үнэмшлүүдийн атрибуц ба өгүүлбэрүүдийн тайлал. Энэ хараат байдлын улмаас ойлголтын схемүүдийг хэлнүүдтэй холбон үзэж болох тухайд өмнө цохож тэмдэглэсэн. Харин одоо энэ санааг үл ялиг хурцаар тавьж болно. Аливаа хүн ямар итгэл үнэмшилтэй (бас юуг санаж зорьж, хүсэж байгаа) талаар хангалттай сайн мэдэхгүй бол түүний хэл яриаг тайлж ойлгох аргагүй гэдгийг, бас хэл яриаг (speech) сайтар ойлгоогүй бол итгэл үнэмшлүүдийг нарийн ялгах боломжгүй гэдгийг хүлээн зөвшөөрө; тэгвэл бид хэл яриаг хэрхэн тайлж ойлгох эсвэл итгэл үнэмшлүүд хийгээд бусад хандлагуудыг ухварлагдахуйцаар тайлбарлах вэ? Нэгэн зэрэг хандлагуудыг тайлбарладаг бас хэл яриаг тайлж ойлгодог онол бидэнд байх ёстой гэдэг нь илэрхий байна — нотолгоонд тулгуурладаг боловч алийг нь ч дэвшүүлдэггүй онол.

Би Куайныг даган, эргэлэг үүсгэлгүйгээр бас баталгаажаагүй үзлүүдэд тулгуурлалгүйгээр, өгүүлбэрүүдэд хандсан маш ерөнхий хандлагуудыг радикал тайллын онолд суурь нотолгоо болгон хүлээн авч болох юм гэх санааг дэвшүүлж байна. Учир нь энэ ярианыхаа төлөө бид ядахдаа өгүүлбэрүүдэд хандсан үнэн гэж хүлээн зөвшөөрөх хандлагыг амин чухал ухагдахуун хэмээн найдаж болох юм. (Илүү цэвэр цусны онол бол үнэн байгаасай гэж хүсэх, үнэн эсэхийг нь гайхан сонирхох, үнэн болгохыг санаж зорих гэх мэт аливаа өгүүлбэрт хандсан бусад хандлагууд өөд бас харна). Энд хандлагууд холбогдсон байгаа нь мэдээж хэрэг, гэхдээ гол асуултаа гуйгаагүй<sup>147</sup> байна гэдгийг дараахаас харж болно: хэрэв бид хэн нэг хүн тодорхой нэг өгүүлбэрийг үнэн хэмээн үзэж байгааг зүгээр л мэдсэн бол, тухайн хүн мөнөөх өгүүлбэрээр ямар утга илэрхийлж байгааг ч, үнэн хэмээн үзэж буй итгэл үнэмшил нь юуг төлөөлж байгааг ч мэдэхгүй. Иймд мөнөөх өгүүлбэрийг үнэн хэмээн үзэж байгаа нь хоёр хүчний (force) вектор болно: тайллын тухай асуудал бол утгын талаарх ажиллахуйц онол хийгээд итгэл үнэмшлийн талаарх хүлээн зөвшөөрөгдөхуйц онолыг нотолгооноос хийсвэрлэж гаргах явдал юм.

Үүнийг шийдвэрлэх арга замыг сэтгэл хөдөлгөм байдлаар маруухан жишээнүүдээс ойлгож болно. Хөвж яваа кечийг (*ketch* хэмээх нэгэн төрөл дарвуулт онгоц) хараад, хамтрагч чинь “Тэр

<sup>147</sup> Орчуулагчийн тэмдэглэл: *Question begging* гэх логик алдааг “асуулт гуйх” хэмээн үгчилж орчуулав.

сайхан яаулыг (*yawl* гэх өөр нэг төрлийн дарвуулт онгоц) хараач” гэж хэлбэл та тайллын асуудалтай тулгарч болно. Найз чинь яаулыг кечтэй андуураад хуурамч итгэл үнэмшил бий болгосон байх боломж бол ердийн л үзэгдэл мөн. Гэхдээ түүний хараа сайн, бас харааны шугам нь зохих түвшинд байгаа бол тэр “яул” гэх үгийг тантай ижил байдлаар хэрэглэдэггүй бас тэрүүгээр өнгөрч явсан дарвуулт онгоцны шургийн байрлалыг зөв харсан гэдэг нь илүү үнэмшилтэй болж ирнэ. Бид итгэл үнэмшлийн талаарх учирт онолыг хадгалж үлдэхийн тулд үгсийг дахин тайлж ойлгох явдлын (*reinterpretation*) талд шийдвэр гаргах, урьдаас бэлдээгүй ийм тайлал хийх нөхцөлтэй цаг үргэлж тулгардаг. Философичид болохынхоо хувиар бид үгийг хамжааргатайгаар буруу хэрэглэх явдалд хүлцэнгүй ханддаг, бас үр дүнг нь тайлж ойлгоход гаршсан байдаг. Энэ бол үнэн аливаа хүний үнэн хэмээн үзэж буй өгүүлбэрүүдээс утга хийгээд итгэл үнэмшлийн талаарх, ашиглаж болохуйц онолыг босгох үйл явц юм.

Иймэрхүү жишээнүүд нийтлэг итгэл үнэмшлүүд болон өнөө хэрэгжиж буй орчуулгын аргын суурийг эсэргүүцэж хэвийн бус (*anomalous*) деталь зүйлсийн тайллыг онцолдог. Гэвч үүнд оролцож буй зарчмууд дээрх шиг тривиал биш нөхцөлүүдэд ч ижил байх учиртай. Гол асуудал нь ийм юм: хэрэв бид ярьж буй этгээд ямар өгүүлбэрүүдийг үнэн хэмээн үзэж буйг л мэдэж байгаа бол, бас түүний хэлийг өөрсдийнхтэйгөө ижил хэмээн таамаглаж үзэх аргагүй байгаа бол, яригч этгээдийн итгэл үнэмшлийн ихээхэн хэсгийн талаар таамаг тавих эсвэл мэдэхгүйгээр тайлал хийх эхний алхмаа ч хийж дөнгөхгүй. Итгэл үнэмшлийн талаарх мэдлэг үгсийг тайлж ойлгох чадамжаар л дамжиж ирдэг учраас, эхний алхмаа хийх цор ганц боломж нь итгэл үнэмшлийн тухайд ерөнхий байдлаар санал нийлсэн хэмээн үзэх явдал юм.

Яригч мөнөөх өгүүлбэрүүдийг үнэн хэмээн үзэж байгаа үед л үнэний нөхцөлүүдийг олж авах (өөрсдийн маань санал бодолд) шинжийг яригч этгээдийн өгүүлбэрүүдэд хамаатуулснаар бүрэн гүйцэд болсон онолын эхний барагцаа авна. Энгийн байдал, нийгмийн нөхцөлдүүлэг бүхий нөлөөний талаарх совин, бас бидэнд буй эрүүл ухаан (*commonsense*) эсвэл шинжлэх ухаан, тайлбарлаж болохуйц алдааны талаарх мэдлэг зэргийг бодолцож үзэн, дээрх үйл ажиллагааг чадах чинээгээрээ лавшруулан гүйцэтгэх явдлыг чиглэлээ болгоно.

Уг арга нь санал зөрөлдөөнийг үгүй хийх зориулалттай биш, үгүй хийж чаддаг ч зүйл биш: харин санал зөрөлдөөн утгатай байх боломжийг бүрдүүлэх зориулалттай, харин энэ нь хүмүүсийн санал нийлж буй суурь байгууллаас —*ямар нэг* суурь байгуулал— бүхэлдээ хамаарна. Санал нийлэх явдал нь “нэг хэлээр” яригсдын дунд өргөн тархсан, үнэн хэмээн үздэг өгүүлбэрүүдээр илэрч болно, эсвэл өөр нэг хэлээр яригсдад хэлмэрч болж буй хүний гаргасан үнэний онолоор дамжаад өргөн хүрээтэй санал зөвшилцөл байж болно.

Элбэрэл (*charity*) бол сонгож болдог зүйл биш, харин ажиллаж болохуйц онолтой байх нөхцөл учраас, үүнийг хүлээн зөвшөөрснөөр нүсэр алдаанд унаж мэднэ гэж үзэх нь утгагүй хэрэг мөн. Үнэн хэмээн тооцогддог өгүүлбэрүүд хийгээд үнэн хэмээн тооцогддог нөгөө өгүүлбэрүүдийн дунд хамжааргатай шүтэлцээг амжилттай бий болгох хүртэл, бидэнд гаргах алдаа гэж үгүй. Бид элбэрлийг хүчээр хүлээн авдаг; —дуртай дургүйгээс үл хамааран, бусдыг ойлгоё гэж байгаа бол бид дийлэнх хэрэг дээр тэдний зөв хэмээн тооцох учиртай. Элбэрэл, онолын формал нөхцөлдүүлэг хоёрыг нийцүүлэх онолыг гарган авч чадвал харилцааг баталгаатай болгоход шаардлагатай зүйлийг бүгдийг хийжээ. Үүнээс цааш юм хийх боломжгүй, юм хийх шаардлага ч үгүй юм.

Бид санал нэгдэх байдлыг боломжит дээд түвшинд байлгах замаар тайлал хийж бусад хүмүүсийн үгс, бодлыг хамгийн дээд зэргээр нь ойлгомжтой (утгат чанартай) болгодог (үүнд ялгаатай санал бодол гэх мэт тайлбарлах боломжтой алдаа байх орон зай багтана). Ойлголтын релтивизмийг өмгөөлөх зай хаана үлдэж байна вэ? Би бол, итгэл үнэмшлийн ялгааны тухайл хэлсэнтэйгээ тун төстэй зүйлийг ойлголтын схемийн тухайд ч хэлэх учиртай гэж бодож байна: дундын (орчуулагдахуйц) хэл эсвэл дундын санал бодлын суурийг өргөтгөх замаар схем эсвэл

санал бодлын ялгаат байдлын талаарх тунхгуудыг илүү тунгалаг, тод болгодог. Уг хоёр тохиолдлын дундуур зурайсан шугам татах аргагүй нь үнэн. Хэрэв яригчид нь хэрэглэхээс татгалзсан ямар нэг харь өгүүлбэрийг, харилцааны бүлэгтээ суурилоод өөрсөдтэйгөө бат холбогдсон аливаа өгүүлбэр болгож орчуулах сонголт хийсэн бол, үүнийг схемүүдийн ялгаатай байдал гэж үзэхэд уруу татагдаж мэднэ; нотолгоогоо өөр арга замаар гаргах гэвэл санал бодлын ялгааны тухайд ярих нь илүү ойр байж мэднэ. Гэхдээ бусад хүмүүс биднээс өөрөөр бодож буй үед ямар ч ерөнхий зарчим эсвэл нотолгоонд хандах байдал биднийг ойлголтуудад маань гэхээс илүү итгэл үнэмшилд маань ялгаа байна хэмээн шийдвэр гаргахад хүчилж чадахгүй.

Ойлголтын схемийн тухай санаанд, тэгэхээр бас ойлголтын релятивизмын талаарх санаанд нягт утга оноох оролдлого орчуулгын хэсэгчилсэн бүтэлгүйтэлд тулгуурлаж байгаа цагтаа бүрэн бүтэлгүйтэлд тулгуурлах үеийнхээс илүү амжилт олж чадахгүй хэмээн дүгнэх учиртай гэж бодож байна. Сууринд нь буй тайллын арга зүйг тооцож үзвэл, бид бусад хүмүүст биднийхээс эрс ялгаатай ойлголтууд хийгээд итгэл үнэмшлүүд байдаг хэмээн шүүн дүгнэх байр сууринд байж таарахгүй нь.

Өөр өөр схемтэй хоёр хүн хоорондоо харилцах боломжийг, байх аргагүй зүйлд, тодруулбал нейтраль сууринд эсвэл нийтлэг координатын тогтолцоонд хандсан хэрэгцээгүйгээр ажиллах арга замыг олж харууллаа хэмээн тоймлож хэлэх нь алдаа болно. Учир нь схемүүд ялгаатай байдаг гэж үзэх ухварлагдахуйц суурийг олсонгүй. Хүн төрөлтнүүд бүгд —ядаж л хэлээр яригч бүхэн— нийтлэг схем бас онтологийг хуваалцдаг гэх бахдам зүйлийг зарлах нь ч дээрхээс дутахааргүй алдаа болно. Учир нь бид схемүүдийг ялгаатай хэмээн ухварлагдахуйцаар хэлж чадахгүй юм бол, эдгээрийг нэг ижил ч гэж хэлэх аргагүй.

Тайллаар дамжаагүй бодит байдал буюу бүх схем хийгээд шинжлэх ухаанаас гадна байх ямар нэг зүйлийн талаарх ойлголтоос хараат байхаа больсноор бид объектив үнэний тухай ухагдахууныг орхихгүй —харин ч эсрэгээрээ. Схем ба бодит байдлын талаарх дуализмыг тооцож үзвэл ойлголтын харьцангуй байдлыг, бас схемээс харьцангуй байх үнэнийг олж авна. Дээрх догма үгүй бол, ийм төрлийн харьцангуй чанар орхигдоно. Өгүүлбэр үнэний утга хэлнээс харьцангуй хэвээр үлдэх нь мэдээж ч гэлээ, энэ нь аль болох объектив байгаа нь л тэр юм. Схем ба ертөнцийн дуализмыг орхисноор бид ертөнцийг гээхгүй, харин жигтэй авираараа өгүүлбэр бас санал бодлуудыг маань үнэн эсвэл худал болгодог танил объектууддаа эргээд зуучгүйгээр хүрдэг болно.